

МОНГОЛЫН №1 НОГООН ХОТХОН



Хан уул дүүрэг Богдхан уулын бэлд байрлах Ривер гарден I, Ривер гарден II хотхон нь Монголын хамгын том, ногоон орчинг бий болгосон. Энэхүү ногоон орчинг бүрдүүлж буй мод, бут, сөөгийг мод үржүүлгийн газраас авчран ургуулдаг ба Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх тал дээр онцгойлон анхааран ажиллаж 2011-2016 онд нийт 51,000 ш мод, бут, сөөг тарьж ургуулан 60,000м<sup>2</sup> талбайг зүлэгжүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Хотхоны мод, сөөгний титмийн эзлэх талбай 25,087м<sup>2</sup> бөгөөд 1 жилд 2,5 га ой модтой тэнцэх ба 36 сая шоо метр агаар цэвэршүүлж байна. Мөн туршилтаар цэнхэр гацуурыг тарьсан ба жилийн өсөлт нь 50 см хүртэл амжилттай ургаж байна.

ХОТХОНЫ 1 ХҮНД ДҮНДЖААР 8 ШИРХЭГ МОД, БУТ, СӨӨГ,  
25,3м<sup>2</sup> НОГООН БАЙГУУЛАМЖ ОНОГДОЖ БАЙНА.

Мөн зуны улиралд орчныхоо шороо тоосны 37%-50%-ийг өөртөө шингээж, агаарын чийгийг 15-20% ихэсгэж нарны хэт төөнөлтийг 10-15 дахин бууруулдаг.

Навчит модны титэм дуу шуугианы 26%-ийг өөртөө шингээж, 74%-ийг ойлгож сарниулахаас гадна орчны дуу шуугианыг 10-20 дицибеллээр бууруулдаг байна.

Хотхонд таригдсан модны дийлэнх нь нарс Учир нь нарс эфирийн анхилам үнэр ялгаруулахаас гадна нарсан ойн хоёр цаг зугаалахад уушиг 20% цэвэрлэгддэг болохыг эрдэмтэд тогтоосон байдаг.

